



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/239

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар хуралдааны 10 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2.4.9-д тусгагдсан “Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж Хүүхдэд ээлтэй нутаг болно” зорилтын хүрээнд анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа үүрэг хүлээгчдийг чадавхжуулах, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулахад 2,990,000 (хоёр сая есөн зуун ерэн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

• 231010041



Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дүгээр сарын 02 өдрийн .....  
А/28 дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Хүүхэд, гэр бүлийн асуудлаар үүрэг хүлээгчдийг чадавхжуулах үйл ажиллагааны зардал	23	130,000	2,990,000
	Дүн			2,990,000